

**АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН  
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**СУДАЛГААНЫ ТАЙЛАН 2023**

**УЛААНБААТАР ХОТ**

# АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН

## НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү судалгааны зорилго нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу үнэлэхэд оршино.

Уг төслийн үр нөлөөг үнэлэхдээ дараах хоёр асуудалд анхаарал хандуулсан. Үүнд нэгдүгээрт, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хийдэл, зөрчлийг тодорхойлох, хоёрдугаарт, хууль хэрэглээний явц дахь ойлгомжтой байдал, хэрэгжилтийн бодитой байдлыг тодорхойлох замаар хууль санаачлагчид дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн болно.

Монгол Улсын хувьд Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг баталсан. Урт хугацааны хөгжлийн бодлогын “Эрх мэдлийн хуваарилалт, хяналт, тэнцлийг оновчтой болгож, засаглалын тогтвортой байдлыг хангана” гэсний Зорилт 5.1-ийн хүрээнд I үе шат буюу 2021-2030 онд төрийн бодлого, үйл ажиллагааны тогтвортой байдалд эерэг нөлөөтэй сонгуулийн тогтолцоо бүрдүүлэх зорилтыг дэвшүүлсэн билээ.

Хуулийн төслийг хуулиар зохицуулах харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлах, боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагад үндэслэн Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д заасны дагуу хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах бөгөөд хуулийн төсөлд дараах харилцааг зохицуулахаар тусгасан байна. Үүнд:

1. Сонгуульд оролцож буй нэр дэвшигч, нам, эвслээс сонгуульд зарцуулах зардлын хэмжээг бодитой бууруулах, сонгуулийн сурталчилгааг сонгогчдод хүртээмжтэй, ээлтэй зохион байгуулах, тэгш өрсөлдөх боломжийг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох зохицуулалт,
2. Улс төрийн намын бүртгэл, өөрчлөлттэй холбоотойгоор нам сонгуульд оролцохоо илэрхийлэх, хүлээн авах, бүртгэх үйл ажиллагаатай холбоотойгоор гардаг хүндрэл, эрх зүйн тодорхойгүй байдлыг арилгах талаарх нарийвчилсан зохицуулалтууд,
3. Сонгогчдийн нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах үйл ажиллагааны ил тод, нээлттэй, хяналттай байдлыг нэмэгдүүлэх, уг үйл ажиллагаанд төрийн байгууллага болон сонгуульд оролцогч талуудын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр зохицуулалтууд,
4. Санал авах, тоолох, дүн гаргах үйл ажиллагааны ил тод байдал, хяналтыг нэмэгдүүлэх зорилгоор санал хураалтын дүнг санал тоолох төхөөрөмжөөс гадна 100 хувь гар аргаар тоолох буюу хяналтын тооллого хийх, санал авах, хяналтын тооллого хийх үйл ажиллагааг зохион байгуулж буй бүх санал авах байруудад хяналтын камер байрлуулж,

санал авах ажиллагааны явцад гарч болзошгүй зөрчил болон хяналтын тооллого хийх үйл ажиллагааг баримтжуулах зохицуулалт.

Дээрх нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн /цаашид “хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх тооцох аргачлал”<sup>1</sup>-д заасны дагуу дараах үе шаттайгаар гүйцэтгэлээ:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

Судалгааны хүрээг тодорхойлохдоо хуулийн төслийг боловсруулах үндэслэл, шаардлагыг шалгуур болгон дараах байдлаар тодорхойлов.

-Сонгуульд оролцож буй нэр дэвшигч, нам, эвслээс сонгуульд зарцуулах зардлын хэмжээг бодитой бууруулах, сонгуулийн сурталчилгааг сонгогчдод хүртээмжтэй, ээлтэй зохион байгуулах, тэгш өрсөлдөх боломжийг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох зохицуулалт,

-Улс төрийн намын бүртгэл, өөрчлөлттэй холбоотойгоор нам сонгуульд оролцохоо илэрхийлэх, хүлээн авах, бүртгэх үйл ажиллагаатай холбоотойгоор гардаг хүндрэл, эрх зүйн тодорхойгүй байдлыг арилгах талаарх нарийвчилсан зохицуулалтууд,

-Сонгогчдийн нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах үйл ажиллагааны ил тод, нээлттэй, хяналттай байдлыг нэмэгдүүлэх, уг үйл ажиллагаанд төрийн байгууллага болон сонгуульд оролцогч талуудын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр зохицуулалтууд,

-Санал авах, тоолох, дүн гаргах үйл ажиллагааны ил тод байдал, хяналтыг нэмэгдүүлэх зорилгоор санал хураалтын дүнг санал тоолох төхөөрөмжөөс гадна 100 хувь гар аргаар тоолох буюу хяналтын тооллого хийх, санал авах, хяналтын тооллого хийх үйл ажиллагааг зохион байгуулж буй бүх санал авах байруудад хяналтын камер байрлуулж, санал авах ажиллагааны явцад гарч болзошгүй зөрчил болон хяналтын тооллого хийх үйл ажиллагааг баримтжуулах зохицуулалт.

Дээрх агуулгыг Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-д заасны дагуу хуулийн төслийг үнэлэх хүрээг тогтоож, хуулийн төслийн үр нөлөөг

1. Зорилгод хүрэх байдал,
2. Практикт хэрэгжих боломж,

### 3. Ойлгомжтой байдал

4. Хүлээн зөвшөөрөгдөх байдал гэсэн 4 шалгуур үзүүлэлтийг тус тус сонгон авч үнэллээ.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ дээрх 3 шалгуур үзүүлэлтийн хүрээнд тэдгээрийг шалгах хэрэгслийг ашиглан хуулийн төслийн зохицуулалт нь уг хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлага, хуулийн төслийн зорилгод нийцсэн эсэх, зорилгод хүрэх боломжтой байдлаар тусгагдсан эсэх, хуулийн төсөл нь ойлгомжтой, зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хүчин төгөлдөр хууль тогтоомжтой нийцсэн эсэхийг үнэлж, төсвөөс гарах зардлын тооцоог хийж, тэдгээрийн үр дүнд үндэслэн анхаарах, өөрчлөх шаардлагатай зохицуулалтын талаар хуулийн төсөл боловсруулагчид зөвлөмж өгсөн.

Тус үнэлгээгээр Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, тухайн нутгийн өөрөө удирдах байгууллагыг өөрсдийн төлөөллөөр бүрдүүлэх, сонгуулийг нээлттэй, хяналттай зохион байгуулж явуулах удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн орчныг сайжруулахад чиглэсэн нэмэлт, өөрчлөлт оруулах байдлаар боловсронгуй болгож чадах эсэхэд хариулт өгнө.

## ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан Аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс дараах 4 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Ойлгомжтой байдал
4. Хүлээн зөвшөөрөгдөх байдал

**“Зорилгод хүрэх байдал”** гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, тухайн нутгийн өөрөө удирдах байгууллагыг өөрсдийн төлөөллөөр бүрдүүлэх, сонгуулийг нээлттэй, хяналттай зохион байгуулж явуулах удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн орчныг сайжруулахад чиглэсэн нэмэлт, өөрчлөлт оруулах байдлаар боловсронгуй болгож чадах эсэхийг үнэллээ.

**“Хүлээн зөвшөөрөгдөх байдал”** гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зохицуулалт иргэд, байгууллагад хэрхэн нөлөөлөх, түүнийг эдгээр этгээдүүд (хуулийн төсөл шууд нөлөөлөх иргэн, хуулийн этгээд) хүлээн зөвшөөрөх

эсэхийг шалгана. Өөрөөр хэлбэл, тухайн зохицуулалтаар иргэдийн эрх чөлөөг хязгаарлаж байгаа эсэх, аж ахуйн нэгжүүдэд шинээр үүрэг хүлээлгэсэн эсэх, эсхүл тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагаанд нийцэх эсэхийг шалгана.

**“Ойлгомжтой байдал”** гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь ойлгомжтой, логик дараалалтай томъёологдсон эсэх, хуулийн төсөл, түүний зохицуулалтыг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх боломжтой эсэхийг шалгах үүднээс холбогдох этгээдээс санал авах, хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг хийхээр сонголоо.

Хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлын тооцоог тусгайлан хийх тул цаг хугацаа, нөөцийн хэмнэлт хийх үүднээс “зардал тооцох” шалгуур үзүүлэлтийг тусгай Тайланд тусгасан болно.

## **ГУРАВ.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООЖ, ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ**

Аливаа хуулийн зохицуулалт нь хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн байх ёстой учраас юуны өмнө хуулийн төслийн зохицуулалтуудыг хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ, шаардлага, үндэслэл болон зорилготой харьцуулан дараах байдлаар үнэлэх хэсгээ тогтоолоо.

<b>Д/д</b>	<b>Шалгуур үзүүлэлт</b>	<b>Үр нөлөөг үнэлэх хэсэг</b>
1	Зорилгод хүрэх байдал	
2	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	
3	Ойлгомжтой байдал	
4	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	

### **ДӨРӨВ.ҮНЭЛГЭЭ**

#### **4.1.“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ**

**“Зорилгод хүрэх байдал”** шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ, шаардлагад хуулийн төслийн зорилт, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл

баримтлал болон хуулийн төслийн зорилт, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийлээ.

Зорилгод хүрэх байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс сонгосон хэм хэмжээг тухайн хуулийн төслийн зорилго болон хуулийн төслийн үзэл баримтлалд заасан хэрэгцээ, шаардлагыг хангахад чиглэгдсэн эсэхийг судлах замаар үнэлгээг тогтооно.

### **Хуулийн төслийн зорилгыг:**

“Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9-д иргэн нь шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй.” гэж, мөн хуулийн Тавин есдүгээр зүйлийн 2-т “Нутгийн өөрөө удирдах байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн Хурал байна.” гэж, тус зүйлийн 3-т “Аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн Хурлыг дөрвөн жилийн хугацаагаар сонгоно. Эдгээр Хурлын болон сум, дүүргийн Хурлын төлөөлөгчдийн тоо, сонгох журмыг хуулиар тогтооно.” гэж тус тус заасныг баталгаажуулан хэрэгжүүлэх буюу Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, тухайн нутгийн өөрөө удирдах байгууллагыг өөрсдийн төлөөллөөр бүрдүүлэх, сонгуулийг нээлттэй, хяналттай зохион байгуулж явуулах удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн орчныг сайжруулахад чиглэсэн нэмэлт, өөрчлөлт оруулах байдлаар боловсронгуй болгох” гэж үзлээ.

### **Хуулийн төсөл боловсруулах болсон хэрэгцээ, шаардлага**

Монгол Улсад аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг анх 1996 онд батлагдсан Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулиар зохицуулж эхэлсэн нь уг харилцааны эрх зүйн үндсийг тавьсан бөгөөд 2007 онд Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, 2012 онд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, 2020 онд Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль болон өөрчлөгдөж тухайн цаг үеийн нийгэм, эдийн засгийн болоод сонгууль зохион байгуулалтын өөрчлөлттэй уялдуулан орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн харилцааг тухай бүр зохицуулж ирсэн байна.

2020 онд батлагдсан Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн дагуу 2020 оны орон нутгийн ээлжит сонгуулийг зохион байгуулсан бөгөөд түүнээс хойш 2021, 2022, 2023 онуудад орон нутгийн иргэдийн Хурлын Төлөөлөгчийн нийт 100 гаруй удаагийн нөхөн сонгуулийг мөн тус хуулийн дагуу зохион байгуулжээ.

Хуулийн төслийн үзэл баримтлал болон хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээнд дурдсанаар орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах явцад Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан сонгох эрхийн үндсэн

дээр саналаа нууцаар гаргаж, тухайн нутгийн өөрөө удирдах байгууллагыг өөрсдийн төлөөллөөр бүрдүүлэх, сонгуулийг нээлттэй, хяналттай зохион байгуулж явуулах удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн орчныг сайжруулах тал дээр анхаарч хуульчлан зохицуулах шаардлагатай байна гэжээ.

Тухайлбал, сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигчдээс зарцуулах зардлын хэмжээг бууруулах чиглэлээр сонгуулийн сурталчилгааны хуулиар зөвшөөрсөн арга хэлбэр түүний тоо, хэмжээг 50 хүртэл хувиар бууруулах, зардлын дээд хэмжээг тогтоохдоо сонгуулийн зардлыг бууруулах чиглэлийг баримтлах, сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, давхардлыг арилгах, нягтлан шалгах үйл ажиллагааны ил тод, хяналттай байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигч, сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт, мониторинг хийх төрийн бус байгууллагын оролцоог баталгаажуулан хуульчлах, сонгогч нэрийн жагсаалтад бүртгэгдсэн эсэхээ шалгах, буруу бүртгэгдсэн тохиолдолд гомдол гаргах боломж, механизмыг нэмэгдүүлэх, санал тоолох төхөөрөмжөөс гарсан санал хураалтын үр дүнг 100 хувь гар аргаар давхар тоолж хяналтын тооллого хийх зэрэг сонгууль зохион байгуулалтын үйл ажиллагааны ил тод байдал, түүнд тавих хяналтыг нэмэгдүүлэх талаар нарийвчилсан тодорхой зохицуулалтуудыг нэмж хуульчлах шаардлагатайг тодорхойлсон байна.

Түүнчлэн 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт буюу Монгол Улсын Үндсэн хуулийн 19<sup>1</sup> дүгээр зүйлийн 1-д “Нам Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 10-т заасны дагуу байгуулагдаж, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана.” гэж хуульчилсан. Нам улсын хэмжээний бодлого дэвшүүлж, тэрхүү бодлого, мөрийн хөтөлбөрөө бүрэн хэрэгжүүлэхэд бүх шатны нутгийн өөрөө удирдах байгууллагаас хуульд заасны дагуу гаргаж байгаа аливаа шийдвэр, үйл ажиллагаа нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт бүрнээ нийцэж байх шаардлагатай юм. Иймд энэхүү шаардлагад үндэслэн, бүх шатны нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааны бодлогын уялдаа холбоог бүрэн хангахын тулд сум, дүүргийн Хурал нь аймаг, нийслэлийн Хурлын төлөөлөгчдийг төлөөллийн ардчиллын зарчмын дагуу сонгож, аймаг, нийслэлийн Хурлыг бүрдүүлдэг тогтолцоо шаардлагатай гэж дээрх баримт бичгүүдэд дурджээ.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбоотой дараах зохицуулалтуудыг тусгажээ. Үүнд:

#### **20 дугаар зүйл. Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх**

20.5. Улсын бүртгэлийн асуудал хариуцсан **эрхэлсэн** төрийн захиргааны байгууллага сонгогчийг энэ хуулийн 20.4-т заасан цахим хуудаст байршуулсан сонгогчдын нэрийн жагсаалтаас өөрт **жагсаалт дахь өөрийн болон өөрийн байнга оршин суугаа хаягийн бүртгэлд бүртгэгдсэн нийт сонгогчийн** нь холбогдох мэдээлэлтэй танилцах боломжоор хангана.

20.10. Хэсгийн хороо нь сонгогчдын нэрийн жагсаалтыг хүлээн авсан өдрөөс эхлэн өөрийн ажиллах байранд, байргүй бол сум, хорооны Засаг даргын тамгын газрын байранд

сонгогчийн өөрт нь итгэмжлэгдсэн ажилтныг ажиллуулж, сонгогчдод өөрийн болон өөрийн байнга оршин суугаа хаягийн бүртгэлд бүртгэгдсэн нийт сонгогчийн холбогдох мэдээлэлтэй чөлөөтэй танилцах бололцоо олгоно.

**20.12.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 20.9-д заасан хугацаанд хүргүүлсэн сонгогчдын нэрийн жагсаалтад энэ хуулийн 20.9.1, 20.9.3, 20.9.4, 20.9.5 дахь заалт, 23 дугаар зүйлд заасан үндэслэлээр оруулсан өөрчлөлтийг тусгаж сонгогчдын нэрийн жагсаалтыг санал авах өдрөөс гурваас доошгүй хоногийн өмнө улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтсээр дамжуулан хэсгийн хороонд хүргүүлнэ.**

20.15.Улсын бүртгэлийн асуудал хариуцсан **эрхэлсэн** төрийн захиргааны байгууллага сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, нягтлан шалгах, давхардал, зөрчлийг арилгах, танилцуулах журам болон маягт, загварыг энэ хуульд нийцүүлэн **энэ хууль болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нийцүүлэн Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн, тагнуулын байгууллагатай хамтран** батална.

**20.18.Энэ хуульд заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн нам, эвсэл, бие даан нэр дэвшигч, төрийн бус байгууллагын төлөөлөл сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх ажиллагаатай холбогдох журмын дагуу танилцаж болно.**

**23 дугаар зүйл.Сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой гомдлыг шийдвэрлэх журам**

**23.8.Сонгуулийн ерөнхий хороо нь шаардлагатай гэж үзвэл сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой гомдол, мэдээллийн дагуу тухайн гомдол, мэдээллийг шалгахад шаардлагатай мэдээлэл, баримтыг холбогдох байгууллагаас гаргуулан авч, зөрчлийг арилгах асуудлаар эрх бүхий байгууллагад хугацаатай шаардлага хүргүүлэх эрхтэй.**

#### **Үнэлгээ:**

Нэмэлт, өөрчлөлтөөр орох эдгээр зохицуулалтууд нь сонгуулийг нээлттэй, хяналттай зохион байгуулж явуулах удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн орчныг сайжруулахад чиглэсэн нэмэлт, өөрчлөлт болох буюу зохицуулах шаардлагатай асуудлыг шийдвэрлэсэн гэж үзэхээр байна.

Түүнчлэн Үндсэн хуулийн холбогдох зохицуулалтын хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэхээс гадна бодлогын баримт бичгүүд, хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан зорилготой нийцэж, тэдгээрийн хэрэгжилтийг хангахад томоохон түлхэц болохоор байна.



**Дүгнэлт:** Иймд хуулийн төслийн сонгогдсон зохицуулалт нь хуулийн төслийн зорилт болон түүнийг боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад нийцэж байна гэж дүгнэлээ.

#### 4.2. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Хуулийн төслийн сонгогдсон зохицуулалт	Тайлбар
<p><b>20 дугаар зүйл. Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх</b></p> <p>20.5. Улсын бүртгэлийн асуудал хариуцаан <b>эрхэлсэн</b> төрийн захиргааны байгууллага сонгогчийг энэ хуулийн 20.4-т заасан цахим хуудаст байршуулсан сонгогчдын нэрийн жагсаалтаас — өөрт <b>жагсаалт дахь өөрийн болон өөрийн байнга оршин суугаа хаягийн бүртгэлд бүртгэгдсэн нийт сонгогчийн</b> нь холбогдох мэдээлэлтэй танилцах боломжоор хангана.</p>	<p>Одоо мөрдөж байгаа зохицуулалт нь сонгогч нь сонгогчдын нэрийн жагсаалтаас зөвхөн өөрийн мэдээлэлтэй танилцах боломжтой байгаа нь тухайн сонгогчийн оршин суугаа хаяг дээр хууль бусаар бүртгэгдсэн өөр бусад сонгогч байгаа эсэхэд хяналт тавих боломжгүй байдал үүсгэж байна.</p> <p>Иймд тус зохицуулалтыг нарийвчилж сонгогчийн нэрийн жагсаалт үнэн зөв үйлдэгдсэн эсэхэд сонгогчдын өөрсдийн хяналтыг бий болгох, үүнтэй холбоотой боломжийг эрх зүйн хувьд баталгаажуулж өгөх шаардлагатай юм.</p> <p>Сонгогчийн хяналт тавих боломжийг хуулиар бүрдүүлж өгснөөр сонгогч нь төрийн байгууллага, албан тушаалтанд хуулийн дагуу шаардлага тавьж хяналтаа хэрэгжүүлэх боломжтой болно.</p>

<p>20.10. Хэсгийн хороо нь сонгогчдын нэрийн жагсаалтыг хүлээн авсан өдрөөс эхлэн өөрийн ажиллах байранд, байргүй бол сум, хорооны Засаг даргын тамгын газрын байранд сонгогчийн өөрт нь <b>итгэмжлэгдсэн ажилтныг ажиллуулж, сонгогчдод өөрийн болон өөрийн байнга оршин суугаа хаягийн бүртгэлд бүртгэгдсэн нийт сонгогчийн</b> холбогдох мэдээлэлтэй чөлөөтэй танилцах бололцоо олгоно.</p>	<p>Одоо мөрдөж байгаа зохицуулалт нь сонгогч нь сонгогчдын нэрийн жагсаалтаас зөвхөн өөрийн мэдээлэлтэй танилцах боломжтой байгаа нь тухайн сонгогчийн оршин суугаа хаяг дээр хууль бусаар бүртгэгдсэн өөр бусад сонгогч байгаа эсэхэд хяналт тавих боломжгүй байдал үүсгэж байна.</p> <p>Иймд тус зохицуулалтыг нарийвчилж сонгогчийн нэрийн жагсаалт үнэн зөв үйлдэгдсэн эсэхэд сонгогчдын өөрсдийн хяналтыг бий болгох, үүнтэй холбоотой</p>
--	---

	<p>боломжийг эрх зүйн хувьд баталгаажуулж өгөх шаардлагатай юм.</p> <p>Сонгогчийн хяналт тавих боломжийг хуулиар бүрдүүлж өгснөөр сонгогч нь төрийн байгууллага, албан тушаалтанд хуулийн дагуу шаардлага тавьж хяналтаа хэрэгжүүлэх боломжтой болно.</p>
<p><b>20.12.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 20.9-д заасан хугацаанд хүргүүлсэн сонгогчдын нэрийн жагсаалтад энэ хуулийн 20.9.1, 20.9.3, 20.9.4, 20.9.5 дахь заалт, 23 дугаар зүйлд заасан үндэслэлээр оруулсан өөрчлөлтийг тусгаж сонгогчдын нэрийн жагсаалтыг санал авах өдрөөс гурваас доошгүй хоногийн өмнө улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтсээр дамжуулан хэсгийн хороонд хүргүүлнэ.</b></p>	<p>Одоо мөрдөж байгаа зохицуулалтад Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас хэсгийн хороодод хүргүүлсэн сонгогчдын нэрийн жагсаалтад хуульд заасан үндэслэлээр өөрчлөлт орсон тохиолдолд хэрхэх талаар зохицуулалт байхгүй байгаа нь сонгогч нь өөрийн оршин суугаа хаяг дээр хууль бусаар бүртгэгдсэн өөр бусад сонгогч байгаа эсэхэд хяналт тавих боломжгүй байдал мөн адил үүсгэж байгаа юм.</p> <p>Иймд тус зохицуулалтыг нарийвчилж сонгогчийн нэрийн жагсаалт үнэн зөв үйлдэгдсэн эсэхэд сонгогчдын өөрсдийн хяналтыг бий болгох, үүнтэй холбоотой боломжийг эрх зүйн хувьд баталгаажуулж өгөх шаардлагатай юм.</p> <p>Сонгогчийн хяналт тавих боломжийг хуулиар бүрдүүлж өгснөөр сонгогч нь төрийн байгууллага, албан тушаалтанд хуулийн дагуу шаардлага тавьж хяналтаа хэрэгжүүлэх боломжтой болно.</p>

<p>20.15.Улсын бүртгэлийн асуудал хариуцсан <b>эрхэлсэн</b> төрийн захиргааны байгууллага сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, нягтлан шалгах, давхардал, зөрчлийг арилгах, танилцуулах журам болон маягт, загварыг энэ хуульд нийцүүлэн <b>энэ хууль болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нийцүүлэн Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн, тагнуулын байгууллагатай хамтран</b> батална.</p>	<p>Нэг байгууллагаас дангаараа батлан гаргасан акт буюу сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, нягтлан шалгах, давхардал, зөрчлийг арилгах, танилцуулах журам болон маягт, загвар нь сонгуулийн үйл ажиллагааг хэрэгжүүлэгч бусад байгууллагад хүндрэлтэй олон асуудал үүсгэдэг.</p> <p>Иймд хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэхийн тулд тус актыг батлахад сонгуулийн үйл ажиллагаанд гол оролцогч төрийн бусад байгууллагуудыг оролцуулах шаардлагатай байна.</p> <p>Хамтран баталснаар тухайн байгууллагад үүсдэг хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэх боломжтой болно.</p>
<p><b>20.18.Энэ хуульд заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн нам, эвсэл, бие даан нэр дэвшигч, төрийн бус байгууллагын төлөөлөл сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх ажиллагаатай холбогдох журмын дагуу танилцаж болно.</b></p>	<p>Нэр дэвшигчээс тус үйл ажиллагаанл хяналт тавих боломжийг хуулиар бүрдүүлж өгснөөр нэр дэвшигч нь төрийн байгууллага, албан тушаалтанд хуулийн дагуу шаардлага тавьж хяналтаа хэрэгжүүлэх боломжтой болно.</p>

<p><b>23 дугаар зүйл.Сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой гомдлыг шийдвэрлэх журам</b></p> <p><b>23.8.Сонгуулийн ерөнхий хороо нь шаардлагатай гэж үзвэл сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой гомдол, мэдээллийн дагуу тухайн гомдол, мэдээллийг шалгахад шаардлагатай мэдээлэл, баримтыг холбогдох байгууллагаас гаргуулан авч, зөрчлийг арилгах асуудлаар эрх бүхий байгууллагад хугацаатай шаардлага хүргүүлэх эрхтэй.</b></p>	<p>Одоо мөрдөж байгаа зохицуулалт нь сонгогч нь өөрийн оршин суугаа хаяг дээр хууль бусаар бүртгэгдсэн өөр бусад сонгогч байгаа тохиолдолд гомдол гаргаж яаралтай шийдвэрлүүлэх боломжгүй байдал үүсгэж байна.</p> <p>Иймд тус зохицуулалтыг сайжруулж сонгогчийн нэрийн жагсаалт үнэн зөв үйлдэгдсэн эсэхэд сонгогчдын өөрсдийн хяналтыг бий болгох, гомдол гаргах, гомдлоо хурдан шийдвэрлүүлэхтэй холбоотой боломжийг эрх зүйн хувьд баталгаажуулж өгөх шаардлагатай юм.</p> <p>Сонгогчийн хяналт тавих, гомдол гаргах,</p>
---	--

	<p>гомдлоо хурдан шийдвэрлүүлэх боломжийг хуулиар бүрдүүлж өгснөөр сонгогч нь төрийн байгууллага, албан тушаалтанд хуулийн дагуу шаардлага тавьж хяналтаа хэрэгжүүлэх боломжтой болно.</p>
--	--

**Үнэлгээ:**

Одоо мөрдөж байгаа зохицуулалт нь сонгогч нь сонгогчдын нэрийн жагсаалтаас зөвхөн өөрийн мэдээлэлттэй танилцах боломжтой байгаа нь тухайн сонгогчийн оршин суугаа хаяг дээр хууль бусаар бүртгэгдсэн өөр бусад сонгогч байгаа эсэхэд хяналт тавих боломжгүй байгаагаас гадна өөрийн оршин суугаа хаяг дээр хууль бусаар бүртгэгдсэн өөр бусад сонгогч байгаа тохиолдолд гомдол гаргаж яаралтай шийдвэрлүүлэх боломжгүй байна.

Иймд эдгээр зохицуулалтыг сайжруулж сонгогчийн нэрийн жагсаалт үнэн зөв үйлдэгдсэн эсэхэд сонгогчдын өөрсдийн хяналтыг бий болгох, гомдол гаргах, гомдлоо хурдан шийдвэрлүүлэхтэй холбоотой боломжийг эрх зүйн хувьд баталгаажуулж өгөх шаардлагатай юм.

Сонгогчийн хяналт тавих, гомдол гаргах, гомдлоо хурдан шийдвэрлүүлэх боломжийг хуулиар бүрдүүлж, төрийн байгууллагуудыг үүрэгжүүлж өгснөөр сонгогч нь төрийн байгууллага, албан тушаалтанд хуулийн дагуу шаардлага тавьж хяналтаа хэрэгжүүлэх боломжтой болно.

Түүнчлэн нэр дэвшигчээс тус үйл ажиллагаанд хяналт тавих боломжийг хуулиар бүрдүүлж, төрийн байгууллагыг үүрэгжүүлж өгснөөр нэр дэвшигч нь төрийн байгууллага, албан тушаалтанд хуулийн дагуу шаардлага тавьж хяналтаа хэрэгжүүлэх боломжтой болно.

**Дүгнэлт:**

Иймд сонгосон зохицуулалтыг хүлээн зөвшөөрөгдөх боломжтой гэж үзэж байна.

**4.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг Хууль тогтоомжийн тухай хуулийн дараах заалтад заасан шаардлагыг хангасан эсэхэд хариулт өгөх замаар шалгалаа.

**Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага**

Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, нэгдэн орсон олон улсын гэрээнд нийцсэн байна.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Тус хуулийн төслөөр Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг явуулахтай холбоотой тодорхойлох асуудлын зохицуулалтуудыг сайжруулан тусгасан.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Хуулийн төсөл нь хуулийн төслийн зорилттой нийцэж байна.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Тус хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгаагүй.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Зөрчилгүй.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Нэг удаа хэрэгжүүлэх заалт хуулийн төсөлд тусгаагүй.

<p>29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;</p>	<p>Бусад хуулийн заалтыг давхардуулан заагаагүй.</p>
<p>29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;</p>	<p>Тус хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журамд нийцсэн.</p>
<p>29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;</p>	<p>Байхгүй.</p>

<p>29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;</p>	<p>Бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байна.</p>
<p><b>30 дугаар зүйл.Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага</b></p>	
<p>30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;</p>	<p>Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэсэн.</p>
<p>30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;</p>	<p>Нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй.</p>
<p>30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;</p>	<p>Хуулийн төсөлд “тогтмол мэдээлнэ” гэж 26 удаа орсон боловч үүнийгээ нэр томъёоны тодорхойлолтод тусгаж өгөөгүйн улмаас төөрөгдөл үүсгэх боломжтой байна.</p>
<p>30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;</p>	<p>Хүч оруулсан нэр томъёо хэрэглээгүй.</p>

## **ТАВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ ӨГӨХ**

### **1.ҮР ДҮНГ БАРИМТЖУУЛАХ**

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхэд зориулж шалгах хэрэгслийг хэрэглэх явцад ашигласан мэдээлэл тоо баримт, дүгнэлт, оролцогчид, мэргэжлийн холбоодын санал зэрэг холбогдох бүх материалыг цуглуулсан бөгөөд хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх үе шат бүрийг баримтжууллаа. Энэ нь хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааны үр дүнг дүгнэж, зөвлөмж өгөх үндэслэл болох бөгөөд цуглуулсан бүх баримт, мэдээлэл зөвлөмжийн хавсралт болно.

## **2.ҮНЭЛЭХ**

Хуулийн төслийн үр нөлөөг шалгах хэрэгслийг ашиглан үнэлэхэд дараах хүндрэлтэй асуудлууд гараагүй болно.

Хуулийн төслийн үр нөлөөг Зорилгод хүрэх байдал, Хүлээн зөвшөөрөгдөх байдал, Ойлгомжтой байдал гэсэн шалгууруудаар ерөнхийд нь үнэлэхэд Хууль тогтоомжийн тухай хуулийн хуулийн төсөлд тавигдах шаардлагыг хангасан гэж дүгнэхээр байна.

## **3.ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ ӨГӨХ**

Хуулийн төсөл нь сонгосон шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд хуулийн төслийн үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг хангасан, хүлээн зөвшөөрөгдөх байдал, ойлголмжтой байдал сайтай байна.